

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

“НИЙСЛЭЛИЙН 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”
ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

/2023 оны жилийн эцсийн байдлаар/

2023 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

№	Бодлогын зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Багтагдсан төсөв	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр(сая төгрөг)өссөн	Зорилтот түвшин, ур дунгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Үнэлгээний тайлбар	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

5. ТАВ. ЗАСАГЛАЛ

1.	5.3. Мэргэшсэн, чадварлаг, иргэндээ үйлчилдэг, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.	5.3.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад болон олон улсын чанарын менежментийн тогтолцоо, стандартыг нэвтрүүлсэн байна.	2021-2025	-	-	34	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2016 стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд нийт 20 байгууллагын дэд ажлын хэсэгт тус газрын 7 албан хаагчид ажиллаж, чанарын Менежментийн тогтолцоог нэвтрүүлэхэд арга зүйгээр ханганд ажиллаж байна.	70	-	НЗДТГ ХСХГ
----	--	---	-----------	---	---	----	---	----	---	------------

8. НАЙМ. БУС ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

2.	8.1. Монгол улсын үндэсний түвшний хөгжлийн бодлоготой нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулж, дагуул хаяа хот, тосгодын хөгжлийг	8.1.7. Улаанбаатар хотод серег нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.	2021-2025	-	-	1	Хот байгуулалт хөгжлийн газартай хамтран ажиллах талаар 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 01/730 дугаартай албан бичиг хүргүүлсэн ба 2023 оны төсөвт хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй тул цаашид хэрэгжүүлэх боломжгүй болсон тухай тус газрын 2/1692 дугаартай албан бичгээр хариу ирсэн.	90		НХБХГ НМХГ НШҮҮ ИГ ХСХГ
----	---	--	-----------	---	---	---	--	----	--	-------------------------

1	2	3	4	5	6	7	8	9	10	11		
	эрчимжүүлж, хотын төвлөрлийг сааруулах бодлогыг боловсруулна.						Энэ чиглэлийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Амартувшинээс албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус газрын барилгын материалын улсын байцаагчид Хан-Уул дүүргийн 20 дугаар хороонд байрлах Тэмдмэнт бетон зуурмагийн үйлдвэрт төлөвлөгөөт бус хяналт шалгалт явуулж иргэдийн эрүүл аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй тус бетон зуурмагийн үйлдвэрийг үйлдвэрийг Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороонд нүүлгэхээр шийдвэрлэсэн. Түүнээс гадна Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, "Жайка"-н Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран зохион байгуулсан "Үйлдвэрийн хаягдال усны хяналт, бизнесийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээний дүрэм, журам, тогтолцооны талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх" хэлэлцүүлэгт оролцож байгууллагын чиг үүргийн хүрээнд санал өгч ажиллав.					

9. ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

3.	9.3 байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн байгуулалтын дундын мэдээллийн санг өргөжүүлэн иргэд,	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурисан газар олгох, барилга барих зөвшөөрлийг иргэд, олон нийтэд нээлттэй болгосон байна.	Үйл	9.3.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурисан газар олгох, барилга барих зөвшөөрлийг иргэд, олон нийтэд нээлттэй болгосон байна.	2021- 2025	-	-	1	Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгавар, "Шил" ажиллагааны хүрээнд Нийслэлийн хэмжээнд ашиглалтад орсон нийт 883 барилга байгууламжийн комиссын дүгнэлт, холбогдох мэдээллийг нэгтгэн www.shilen.gov.mn -д байршуулахаар Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. Үүнд: -2009-2012 онд ашиглалтад орсон 155 барилгын мэдээллийг Үндэсний Архивын газрын баримтаас шүүж нэгтгэсэн.	90	-	НХБХГ НГЗБА ХСХГ НМТГ
----	--	---	-----	--	---------------	---	---	---	--	----	---	--------------------------------

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
	олон нийтэд нээлттэй болгон, тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ.						-2020-2023 онд ашиглалтад орсон 728 барилгын мэдээллийг байгууллагын цахим архив, мэдээллийн сангаас шүүж нэгтгэсэн.			
4	9.5. Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	9.5.1 Хот төлөвлөх, байгуулах үйл ажиллагаанд болон нийгмийн үйлчилгээний барилгын стандартыг мөрдүүлдэг тогтолцоог болгоно.	бий	2021-2025		Хот төлөвлөх, байгуулах стандарт 45, Төрийн болон нийгмийн үйлчилгээн ий барилга 213	<p>1.Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрдөх хотын стандартын төслийг боловсруулан 2022 онд 9 бүлгийн 38, 2023 онд 7 бүлгийн 14 хотын стандартыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан.</p> <p>2.Хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжаар удирдамж, нэгдсэн төлөвлөгөө батлуулсан. Төлөөлөгөөнд хотын стандартыг сурталчлах, зөвлөмж арга зүйгээр хангах, судалгаа хийх, хяналт шалгалт гэсэн үндсэн 4 чиглэлээр нийт 126 арга хэмжээ тусган хэрэгжүүлж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хотын стандартын талаарх мэдлэг, ойлголт өгөх сургалтыг 18 удаа зохион байгуулж нийт 1821 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөллийг хамруулсан. - Нийслэлийн хэмжээнд барилга угсралтын ажил гүйцэтгэж буй нийт 698 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийсэн. Үүнээс 27 аж ахуйн нэгжид албан шаардлага хүргүүлж, зөвшөөрөлгүй 3 аж ахуйн нэгж, байгууллага, 5 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 17.500.000 төгрөгийн тортогтууль ноогдуулсан. 	90	-	ХСХГ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
							<ul style="list-style-type: none"> - Нийслэлийн хэмжээнд нийт 382 байршилд барилгын түр байгаагаас 197 байршлын 751 объектод хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар улсын /ахлах/ байцаагчийн 117 зөвлөмж, 27 аж ахуйн нэгж байгууллагад албан шаардлага хүргүүлж барилгын түр хашааны стандартыг хангулсан. - Батлагдсан ерөнхий төлөвлөгөөг мөрдөж ажиллах тухай 2023 оны 01/157 дугаартай албан мэдэгдлийг Хот байгуулалт, хөгжлийн газар, Орон сууцны бодлогын газар, мөн зураг төслийн 127 байгууллагуудад хүргүүлж, холбогдох норм ба дүрмийг зөрчиж олгосон зөвшөөрлийг цуцлах талаар 47 мэдэгдэл хүргүүлж, 3 байршилд улсын байцаагчийн дүгнэлт гарган Нийслэлийн Засаг даргын захирамжаар түр түдгэлзүүлж, зөрчилтэй 2 ААНБ-д Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээг авч, зөрчлийг арилгуулсан. 3. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжийн хүрээнд худалдаа, үйлчилгээний байгууллагын гадна орчин, хаягийн байгууламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжтэй байдалд хяналт шалгалт хийж, 95 аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөмж хүргүүлж 35 худалдаа үйлчилгээний байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэний налуу замыг 			

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
							стандартын дагуу хийж, тохижуулсан байна. 4.Төрийн болон нийгмийн үйлчилгээний 43 барилгыг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй, стандартын шаардлагын дагуу болгох үүрэг даалгавар өгч, биелэлтийг хянаж байнгын ашиглалтад оруулсан.			
5		9.5.3 Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулсан байна.	2021-2025	-	-		Орчны аюулгүй байдлыг хангуулах хүрээнд дараах томоохон ажлыг хэрэгжүүлсэн байна. Үүнд: - Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамжийн хүрээнд 9 дүүргийн хэмжээнд хамтарсан хяналт шалгалт хийж иргэдийн амьдрах орчинд эрсдэл учруулж болзошгүй зерчлүүдийг илрүүлж улсын байцаагчийн зөвлөмж 120, зөрчил дутагдал арилгах тухай мэдэгдэл 93, дутагдал арилгуулах албан шаардлага 42 хүргүүлсэн. Мөн орчны аюулгүй байдлыг алдагдуулсан 54 ААНБ-ын үйл ажиллагааг зогсоож ажилласан. - Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/863 дугаар захирамжийн хүрээнд орчны аюулгүй байдал алдагдсан-90, зөвшөөрөлгүй барилгын суурийн нүх ухсан-16 байршилд холбогдох байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалт хийсэн. Зөвшөөрөлгүй суурийн нүх ухсан 2 байршилд зөрчлийн хэрэг нээж, улсын (ахлах) байцаагчийн албан шаардлага хүргүүлж барилгын суурийн нүхийг булж, нөхөн сэргээлт хийсэн. 86 байршилд барилгын түр хашааны стандартыг хангуулсан.	100	-	ХСХГ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
							<ul style="list-style-type: none"> - "Барилгын хог хаягдлын менежмент" хотын стандартын шаардлагыг хангуулах талаар 144, "Аюултай хог хаягдлын менежмент" хотын стандартын шаардлагыг хангуулах талаар 21, "Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага" хотын стандартын шаардлагыг хангуулах талаар 70, нийт 235 аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөмж хүргүүлсэн. - Хотын стандартын хэрэгжилтийг хангуулж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чиглэсэн судалгаа, мэдээллийг 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 01/877 дугаар албан бичгээр Хүний Эрхийн Үндэсний комиссын Тамгын газарт хургуулсан. 			

Дундаж биелэлт


88%

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



С.ТӨМӨРДУЛАМ

Э.ДАВААХАТАН

Г.ЭНХЭЭ

М.Гачмаа

М.ГАЧМАА